

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

#### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 15

Хуралдаан 2013 оны тавдугаар сарын 17-ний өдрийн 14 цаг 30 минутад эхэлж, 17 цаг 06 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 2 цаг 36 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Бусад асуудал: - Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнийг төрийн өндөр албан тушаалтны зэрэг, зиндаа түүнтэй адитгах албан тушаалтны зэрэглэлд хамааруулах тухай	1. Монгол Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаатай адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл”-ийн ТӨ-ҮА-д “Төрийн албаны зөвлөлийн дарга” гэсний дараа “Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн” гэж нэмэх саналыг дэмжих 2. Шүүхийн захиргааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д зааснаар шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Засгийн газрын гишүүнтэй адил байхаар заасан байх тул Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга нь дээр дурдсан Улсын Их Хурлын тогтоолоор баталсан ангилал, зэрэглэлийн захиргааны албан тушаалын ТӨ- ҮА-д хамаарах боломжтой байна гэсэн саналыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын Байнгын хороонд хүргүүлэх нь зүйтэй гэж үзэв
2	Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг батлах тухай	Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3 дахь хэсгийг баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн

		<p>хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Яам, агентлаг, аймаг, нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишгийг хавсралтаар батлах.</p> <p>2. Тогтоолыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдэд хүргүүлж, Салбар зөвлөлүүдийн бүрэлдэхүүнийг энэхүү нийтлэг жишигт нийцүүлэн өөрчлөлт оруулах саналыг 2013 оны 6 дугаар сарын 05-ны дотор авч, нэгтгэн Төрийн албаны зөвлөлийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэхийг Ажлын албаны дарга (С.Цэдэндамба)-д даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Зарим аймгийн ИТХТ-ийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай</p>	<p>а. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулсан комиссын тайланг хэлэлцээд Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 9, 32, 33, 39 дүгээр зүйлийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаас дээр дурдсан албан тушаалд тавигдах шаардлагыг мэдлэг, боловсрол, мэргэжил, туршлага, мэргэшлийн ур чадварын хувьд хангаж байгаа:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Калекийн Баймуратыг Баян-Өлгий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын</li> <li>2. Даваасүрэнгийн Батчулуун, Батмөнхийн Бат-Амгалан, Цагааны Жаргалсайхан нарыг Булган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын</li> <li>3. Чимбийн Амарсанааг Говь-Алтай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын</li> </ol>

		<p>4. Цангиагийн Балхярвааг Завхан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын</p> <p>5. Жадамбаагийн Жаргалсайханыг Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын</p> <p>6. Амгалангийн Идэргүрэвийг Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын</p> <p>7. Норовын Бөхболдыг Ховд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын</p> <p>8. Өнөрийн Цогбадрахыг Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах албан тушаалтны нөөцийн жагсаалтад бүртгүүлж, сонгон шалгаруулалтын үнэлгээ, онооны дарааллаар өрсөлдөгчөөсөө өндөр оноотой өрсөлдөгчийг тухайн албан тушаалд нь томилуулахаар Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 /нэг нэр дэвшигчийг дэвшүүлэх/ болон УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 33-т заасны дагуу нэр дэвшүүлэн томилох эрх бүхий субъект болох Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Завхан, Сүхбаатар, Төв, Ховд, Хэнтий аймгуудын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт хүргүүлэх нь зүйтэй гэж үзэв.</p> <p>b. Нэр дэвшигчийг томилсон тухайгаа Төрийн албаны зөвлөлд бичгээр мэдэгдэхийг томилох эрх бүхий этгээд болох болох Баян-Өлгий, Булган, Говь-</p>
--	--	--

		<p>Алтай, Завхан, Сүхбаатар, Төв, Ховд, Хэнтий аймгуудын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт тус тус зөвлөх.</p> <p>с. Архангай, Говьсүмбэр аймгуудын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг дахин зарлахаар тогтов.</p>
4	<p>Зарим аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай</p>	<p>а. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулсан комиссын тайланг хэлэлцээд Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 9, 32, 33, 39 дүгээр зүйлийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаас дээр дурдсан албан тушаалд тавигдах шаардлагыг мэдлэг, боловсрол, мэргэжил, туршлага, мэргэшлийн ур чадварын хувьд хангаж байгаа:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Баасангийн Лхагвасүрэнг Архангай аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын,</li> <li>2. Турдханы Манкей, Баатархүүгийн Пагвадорж нарыг Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын,</li> <li>3. Осрондамбын Тойвгоог Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын,</li> <li>4. Цэрэнтүндэвийн Ганболд, Бат-Очирын Эрдэнэбат нарыг Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын,</li> <li>5. Цэндсүрэнгийн Лхамсүрэнг Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын,</li> <li>6. Дамбийнямын Нямдоржийг Төв аймгийн Засаг даргын Тамгын</li> </ol>

		<p>газрын даргын,</p> <p>7. Баасанхүүгийн Батмөнхийг Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын,</p> <p>8. Магваны Болдыг Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын,</p> <p>9. Чулуунбатын Чүлтэмбатыг Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын</p> <p>10. Дэндэвийн Бямбацогт, Ваанчигийн Сумъяасүх нарыг Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах албан тушаалтны нөөцийн жагсаалтад бүртгүүлж, сонгон шалгаруулалтын үнэлгээ, онооны дарааллаар өрсөлдөгчөөсөө өндөр оноотой өрсөлдөгчийг тухайн албан тушаалд нь томилуулахаар Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 /нэг нэр дэвшигчийг дэвшүүлэх/ болон УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 33-т заасны дагуу нэр дэвшүүлэн томилох эрх бүхий субъект болох Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Ховд, Хэнтий, Дархан-Уул, Орхон аймгуудын Засаг дарга нарт хүргүүлэх нь зүйтэй гэж үзэв.</p> <p>b. Нэр дэвшигчийг томилсон тухайгаа Төрийн албаны зөвлөлд бичгээр мэдэгдэхийг томилох эрх бүхий этгээд болох Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Ховд, Хэнтий, Дархан-Уул, Орхон аймгуудын Засаг дарга нарт тус тус зөвлөх.</p> <p>c. Дорноговь, Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны</p>
--	--	---

		сонгон шалгаруулалтыг дахин зарлахаар тогтов. d. Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын дүнг хэлэлцэхийг хойшлуулав.
--	--	--

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ